



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)

№ 0217869

Увс сум хот, сум

2021 оны 08 сарын 08 өдөр

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

Миний нийт байдал зүйлс бүхэл /эрх бүхий албан тушаалтны харьяалах байгууллага, ажил, нэр, цол, зэрэг/ би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ..
..... асуудлыг шалгаад ОЛСОН нь:

Холбогдогч /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг/
.....-нь

болох нь зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна. Иймд холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн зүйлийн -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл оногдуулсугай.
2. Оногдуулсан шийтгэлийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, хохирол, нөхөн төлбөрийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг /улсын төсөвт/ Төрийн сангийн тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.
3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн /үйл ажиллагаа, эрх/ аль болохыг зурах/-ыг хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.
4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан төгрөгийн торгуулийн шийтгэлийг хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:
 - А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/
 - Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/
 - В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/ /аль нь болохыг доогуур зурах/ /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу шийдвэрлэсүгэй.
6. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар-ны өдрийн дотор үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төгрөгийн зардлыг гаргуулсугай.
7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.
8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан /..... / (нэр)

ТАНИЛЦСАН:

Холбогдогч /..... / (нэр)



2021 оны 08 сарын 08 өдөр

АГУУЛГА

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	4
ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
ТАВ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	22
НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
ДҮГНЭЛТ	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйлдвэрийн хашаанд усалгаа хийж буй байдал	6
Зураг 2. Бохир усны шинжилгээ	7
Зураг 3. 2022 оны ус бохирдуулсны төлбөр тооцоо хийгдсэн байдал	7
Зураг 4. Химийн бодисын агуулах	8
Зураг 5. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж батламж авсан байдал	10
Зураг 6. Ногоон байгууламжийн арчилгаа, тордолтыг хийж буй байдал	11
Зураг 7. Анхны тусламжийн багаж хэрэгсэл байршуулсан байдал	15
Зураг 8. ХАБ зааварчилгаа өгч буй байдал	16
Зураг 9. Ажилчдад сургалт зохион байгуулж буй байдал	17
Зураг 10. Ундааны үйлдвэрийн хог хаягдлын цэгт	19
Зураг 11. Энгийн хог хаягдлыг гэрээний дагуу ачуулан зайлуулж буй байдал	20
Зураг 12. Цаасан хайрцаг, рулоны гол	21
Зураг 13. Хаягдал хуванцар сав болон гялгар уут	21
Зураг 14. Хөрсний болон агаарын шинжилгээ хийлгэсэн байдал	23
Зураг 15. Аюултай хог хаягдал болон дахин боловсруулах хог хаягдал нийлүүлэх гэрээний сунгалт хийлгэсэн байдал	25
Зураг 16. Устгалд оруулсан аюултай хог хаягдлын акт	26
Зураг 17. Гэрээний сунгалт хийлгэсэн байдал	27
Зураг 18. ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын тогтоол гарсан байдал	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлууд ...	4
Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	9
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ...	12
Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	13
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	18
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	22
Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 9. БОМТ-ий хэрэгжилтийг олон нийтэд тайлагнасан байдал	28
Хүснэгт 10. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	30

НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жи Эн Бевережис” ХХК нь 2008 онд гадаад худалдаа, ундаа жүүсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр байгуулагдсан. 2008 оны есдүгээр сард АНУ-ын ПэпсиКо Интернэшнлтэй хамтын ажиллагаагаа эхлүүлснээр дэлхийд алдартай брэндүүдийг эх орондоо үйлдвэрлэж, дотоодын үнээр хэрэглэгчиддээ хүргэж эхэлсэн бөгөөд 2017 онд ОУ-ын FSSC 22000 стандартыг Монголд хэрэгжүүлэгчийн сертификат гардаж авснаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын хоёр дахь үндэсний үйлдвэрлэгч компани болсон.

“Пепси” ундааны үйлдвэр нь Pepsi, Lipton Ice Tea, Mountain Dew, Sting, 7Up, Miranda гэсэн 14 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дөрвөн төрлийн савлагаатайгаар үйлдвэрлэж, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 300 гаруй сумын 10000 гаруй харилцагчдад худалдаалдаг. Цагт 18000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Мөн POSTMIX машинд зориулсан 20 летрийн савалгаатай 4 төрлийн ВВВ сиропыг үйлдвэрлэдэг ба цагт 600 сав бүтээгдэхүүнийг савлах хүчин чадалтай.

2023 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тооцооноос үзэхэд жилд 21 сая орчим, хоногт 57534 ширхэг ундаа үйлдвэрлэсэн байна. Одоогоор 238 гаруй ажилтантай, маркетингийн газар, борлуулалтын газар, санхүүгийн газар, үйлдвэрийн газар, гадаад харилцаа төлөвлөлтийн алба, захиргаа хүний нөөцийн алба, инженер техникийн алба, түгээлт ачилт гэсэн албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“Жи Эн Бевережис” ХХК-ийн “Пепси” ундааны үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Пепси” ундааны үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан /2024-2028 он/, тус үйлдвэрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1.	Үйлдвэрийн орчимд сул шороон талбайгаас тоосжилт үүсэх	Үйлдвэрийн гадаах орчны тоосжилтын хэмжээг бууруулах, услах	Төслийн талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайг автомат усалгааны системээр усалгааг тогтмол хийсэн.	-		2000.0		2023 онд	Агаарын тухай хууль MNS 4585:2007 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
2.	Хөрсний эвдрэл, бохирдол, доройтол	Үйлдвэрийн лаборатори болон ариутгал халдваргүйжүүлэлтийн зориулалтаар хэрэглэх химийн бодисоор хөрс бохирдохоос сэргийлэх, химийн бодис хольцуудыг битүүмжлэл сайтай стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах	Үйлдвэрийн химийн бодисыг зориулалтын агуулахад хадгалдаг. Химийн бодисоор хөрсөн бүрхэвч бохирдохоос урьдчилан сэргийлж аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг чанд мөрдөн ажилласан.	-		50000.0		2023 онд	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260: 2011
Гадаргын ба газрын доорх усны нөөц									

**“ПЕПСИ” УНДААНЫ ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

3.	Газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Саарал усыг ариун цэврийн өрөөний суултуурт ашиглах, үйлдвэрийн доторх угаалга цэвэрлэгээнд ашиглах, хотын ногоон байгууламжийн усалгааг хийх, барилгын материалын үйлдвэрүүдэд нийлүүлж хамтран ажиллах	Үйлдвэрийн технологийн хэрэглээнээс хоногт 10м ³ саарал ус гардаг. Тус саарал усны оффисын ажилчдын ариун цэврийн өрөөний суултуурын усанд ашигладаг. Мөн үйлдвэрийн ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.	-	100.0	2023 онд	Усны тухай хууль, 2012 он Ундны усны чанарын стандарт MNS0900:2018 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
Бүх зардал					52100.0		

“Пепси” ундааны үйлдвэр нь Reverse osmosis (RO) ус боловсруулах системтэй. Тус систем нь цагт 40м³ хүчин чадалтай ба 6ш мембран шүүлтүүрээр гарч буй усны 12.5% нь хаягдал болон гардаг.

“Пепси” ундааны үйлдвэр нь 2022 онд суурилуулсан усалгааны Reverse osmosis (RO) ус боловсруулах системээс гарч буй хаягдал усыг үйлдвэрийн гадна орчны тоосжилтын хэмжээг бууруулах зорилгоор ашиглан тогтмол усалгаа хийж байна.



Зураг 1. Үйлдвэрийн хашаанд усалгаа хийж буй байдал

Мөн ундааны үйлдвэрийн технологийн хэрэглээнээс саарал ус гардаг. Тус саарал усыг оффисын ажилчдын ариун цэврийн өрөөний суултуурын усанд ашигладаг. Мөн үйлдвэрийн ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.

“Пепси” ундааны үйлдвэр нь 2022 онд ус бохирдуулсны төлбөрийг төлж 2023 онд 2 дугаар сард хаягдал усны дүгнэлтийг Усны газраар гаргуулсан бөгөөд үйлдвэрээс гарч буй бохир усны шинжилгээг хийлгэсэн.



Зураг 2. Бохир усны шинжилгээ

“Жизнбевережис” ХХК-ийн 2022 оны ус бохирдуулсны төлбөрийн тооцоо

№	Бохирдуулах бодисын төрөл	MNS 6561:2015 стандартын ЗДХ	Хаягдал усны сорьц дахь бохирдуулах бодисын дундаж агууламж		Хаягдал усны хэмжээ, м ³	Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр
			мг/л	кг/м ³			хэмжих нэгж	тариф	
1	2	3	4	5	6	7=4*6*(10) ⁻³	8	9	10=7*9
1	Органик бодис /ХХХ/	800	800	0.8	59620	47696	төг/кг	50	2,384,800.00
2022 оны I, II, IV улирлын ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр									2,384,800.00
1	Жинлэгдэх бодис	400	3	0.003	26570	79.71	төг/кг	50	3,985.50
2	Органик бодис /ХХХ/	800	96	0.096	26570	2550.72	төг/кг	50	127,536.00
3	Органик бодис /БХХ/	400	36.18	0.03618	26570	961.3026	төг/кг	50	48,065.13
4	Органик бодис /нийт азот/	30	0.31	0.00031	26570	8.2367	төг/кг	50	411.84
5	Эрдэс бодис /фосфор/	5	0.25	0.00025	26570	6.6425	төг/кг	20	132.85
2022 оны III улирлын ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр									180,131.32
2022 оны ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр									2,564,931.32

Зураг 3. 2022 оны ус бохирдуулсны төлбөр тооцоо хийгдсэн байдал

“Пепси” ундааны үйлдвэрийн лаборатори болон ариутгал халдваргүйжүүлэлтийн зориулалтаар хэрэглэх химийн бодисоор хөрс бохирдохоос сэргийлж, химийн бодис хольцуудыг битүүмжлэл сайтай стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах зорилгоор химийн бодисын агуулах байгуулсан. Химийн бодисоор хөрсөн бүрхэвч бохирдохоос урьдчилан сэргийлж аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг чанд мөрдөн ажилласан. Химийн бодисын агуулахын дүгнэлттэй.



Зураг 4. Химийн бодисын агуулах

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Үйлдвэрийн хашаан доторх элэгдэж доройтсон хөрсөн гадаргыг нөхөн сэргээх	“Пепси” ундааны үйлдвэрийн ногоон байгууламжийг арчлах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлдэг аж ахуйн албатай. Тус алба нь ногоон байгууламжийн усалгаа, нөхөн тарилт, цэнэг усалгаа зэрэг ажлуудыг тогтмол хэрэгжүүлдэг.	Орчны бохирдлыг бууруулах			500.0	500.0	2023 онд	
2.	Дүйцүүлэн хамгаалын ажил хийх	”Жи эн бевережис” ХХК нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2022, 2023 онуудад үйлдвэрийн ажилтнууд Туул голын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж ургуулсан. Тус санамж бичгийн хүрээнд 2022-2023 онуудад 517 мод тарьж ургуулсан байна.	Дүйцүүлэн хамгаалал			15000.0	15000.0	2023 онд	
Нийт зардал							15500.0		

Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Жи эн бевережис” ХХК нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй 2022-2025 онуудад хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан бөгөөд тус санамж бичгийн хүрээнд 2022-2023 онуудад 517 ш мод тарьсан байна.

2023 онд “Жи эн бевережис” ХХК-ийн ажилтнууд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Туул голын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж батламж авсан байна.



Зураг 5. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж батламж авсан байдал

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хамтран төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд тус санамж бичгийн хүрээнд 2 га талбайд мод тарьж, тохижуулсан. Үйлдвэрийн эдэлбэр газрын 17% буюу 3202.6м² талбайд ногоон байгууламж байгуулсан.



Зураг 6. Ногоон байгууламжийн арчилгаа, тордолтыг хийж буй байдал

ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	Пепси ундааны үйлдвэрийн 1. талбайд түүх соёлын өв, дурсгалт газар, олдвор байхгүй				Байхгүй			Соёлын өвийг хамгаалах тухай хууль Газрын тухай хууль
	Нийт зардал					-		

ТАВ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	ХХАА-ны дүрэм журам зөрчигдөж үйлдвэрийн осол гарах	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг таниулах заавар зөвлөмжийг тогтмол өгч ажилладаг ба анхны тусламжийн багаж хэрэгслийг үйлдвэр, агуулах, лаборатори гэсэн шаардлагатай байгаа 5-н хэсэгт шинээр байрлуулсан.	Үйлдвэрийн хэмжээнд		500.0		2023 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 он Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлагаMNS 4244:94
2.	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аварт өртөх	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, аливаа осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант хугацаанд	Үйлдвэрийн хэмжээнд		1000.0		2023 онд	Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлагаMNS 4244:94
3.	Химийн бодисын аюулгүй ажиллагаа зөрчигдөх	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны эрүүл ахуй сургалт /33 хүн/ - Даралтад савны сургалт / 11 / 1 сарын 4 - Даралтад савны сургалт /сертификаттай/ - 5/4 нд 37 ажилтанд 5/20 28 хүн, 9/8нд 30 хүнд тус тус гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт - ХАБ-ын сургалт /12 хүнд/ - хийн даралт сав аммиакийн ашиглах зааварын талаар 10 сарын 4нд - Сэрээт өргөгчийн операторийн сургалт 4 хүн үнэмлэхтэй - Аммиакийн ашиглах сургалт -аас 11 сарын 22 /11 хүн/ <p>Дээрх сургалтуудыг 1, 5, 10, 11 дүгээр саруудад “Цогзориг” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Алтан чадамж” ХХК, “Цог зориг” ХХК, “Dryger” ХХК-тай хамтарч зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 162 ажилчид хамрагдсан байна.</p>	Үйлдвэрийн ажилчдад				Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94 Гал гарах үед анхааруулгын самбар, объектоос гарах схем зураглал, галын хорын	

						нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566: 2005
Нийт зардал				1500.0		



Зураг 7. Анхны тусламжийн багаж хэрэгсэл байршуулсан байдал

Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг таниулах заавар зөвлөмжийг тогтмол өгч ажилладаг ба анхны тусламжийн багаж хэрэгслийг үйлдвэр, агуулах, лаборатори гэсэн шаардлагатай байгаа 5-н хэсэгт шинээр байрлуулсан.

Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, аливаа осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тайлант хугацаанд

- Ажлын байрны эрүүл ахуй сургалт /33 хүн/
- Даралтад савны сургалт / 11 / 1 сарын 4
- Даралтад савны сургалт /сертификаттай/
- 5/4 нд 37 ажилтанд 5/20 28 хүн, 9/8нд 30 хүнд тус тус гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт
- ХАБ-ын сургалт /12 хүнд/
- хийн даралт сав аммиакийн ашиглах зааварын талаар 10 сарын 4нд
- Сэрээт өргөгчийн операторийн сургалт 4 хүн үнэмлэхтэй
- Аммиакийн ашиглах сургалт -аас 11 сарын 22 /11 хүн/

Дээрх сургалтуудыг 1, 5, 10, 11 дүгээр саруудад “Цогзориг” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Алтан чадамж” ХХК, “Цог зориг” ХХК, “Dryger” ХХК-тай хамтарч зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 162 ажилчид хамрагдсан байна.



Зураг 8. ХАБ зааварчилгаа өгч буй байдал



Зураг 9. Ажилчдад сургалт зохион байгуулж буй байдал

ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн хатуу хог хаягдлаар	Ахуйн хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг сард 1 удаа хийж ажилласан.	Тогтмол	-	-	-	2000.0	2023 онд	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:
2.	орчныг бохирдуулах	Дахин боловсруулах боломжгүй хаягдлыг дүүргийн тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу ачуулан зайлуулдаг. Мөн гэрээнд заасанчлан хог хаягдлын төлбөрийг хугацаанд нь төлж ажилласан.	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	-	1420.0	7 хоногт 1 удаа	2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
3.	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажил	“Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагаанаас ундааны гологдол хуванцар сав, модон болон хуванцар подон, бүтээгдэхүүний цаасан хайрцаг зэрэг хаягдлууд гардаг. “Мультипак” ХХК-дад хамтран ажиллах гэрээний хүрээнд нийлүүлэн дахин боловсруулалт хийж ажилласан.	Аюултай хог хаягдал	-	-	-	1000.0	2023 онд	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, ЗГ-ын 2018 оны 116-р тогтоол
Нийт зардал:							4420.0		

“Жи Эн Бевережис” ХХК нь орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг сард 1 удаа хийж ажилласан.



**Зураг 10. Ундааны үйлдвэрийн хог хаягдлын цэгт
ариутгал хийж буй байдал**



Зураг 11. Энгийн хог хаягдлыг гэрээний дагуу ачуулан зайлуулж буй байдал

“Пепси” ундааны үйлдвэрийн үйл ажиллагаанаас ундааны гологдол хуванцар сав, модон болон хуванцар подон, бүтээгдэхүүний цаасан хайрцаг зэрэг хаягдлууд гардаг. Дээрх хаягдлуудыг “Мультитак” ХХК-дад хамтран ажиллах гэрээний хүрээнд нийлүүлэн дахин боловсруулалт хийж ажилласан.



Зураг 12. Цаасан хайрцаг, рулоны гол



Зураг 13. Хаягдал хуванцар сав болон гялгар уут

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Байгаль орчны бүрдлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгж зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар	Тоос /PM10, PM2.5/, CO ₂ , SO ₂ , NO ₂	Үйлдвэрийн орчинд	Жилд 2 удаа	-	-	-	Үйлдвэрийн гадна орчинд агаарын шинжилгээ хийгдээгүй бөгөөд харин үйлдвэрийн дотоод орчинд 3, 10 дугаар саруудад агаарын хяналтын шинжилгээг 2 удаа өөрийн лабораторид хийсэн.	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5885: 2008/ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
2.	Хөрс	Хөрсөн дэх бичил биетний тоо (1гр-д) Колититр Cl.perferringens титр		Жилд 1 удаа			50.0	Хөрсний хяналтын 1 цэгээс дээж авч “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хөрс судлалын лабораторит задлан шинжлүүлсэн. Хөрсний эрүүл ахуйн бохирдолгүй гарсан.	Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл/MNS 3985 - 1987/ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008. Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991
		Хөрсний үржил шим тодорхойлох							
		Хөрсөн дэх хүнд металлын агууламж тодорхойлох							
Нийт							50.0		

“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
РСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Улаанбаатар, Улаанбаатар дот. Сүхбаатар дүүрэг
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com
Заснагач: “Хос нэхэн” ХХК
№ 23/10-18/1

Тогсон ажиллагаа: “Хос нэхэн” ХХК, ХУД 5-р хороо
Сорьч авсан өгнөө: 2023 оны 10 сар 13 өдөр
Шинжилгээ хийсэн өгнөө: 10 сарын 18
Харилцах тусгагч:

№	Дэглэлийн дугаар	Бусад стандарт		Галтны стандарт		Ажирлын стандарт	
		MNS6341:2012	Шинжилгээний харуу	(E.coli)/MNS 5367:2004	Бохирын эзрэг	6341:2012	Шинжилгээний харуу
1	Дэглэ 1	3.9*10 ⁵	1	1	1	0.1<	1

2. ХӨРСНИЙ ХУНЦ МЕТАЛЛЫН ТҮҮ ДЭЛЭГҮҮД

Дэглэ авсан газар, Газар зүйн байршил	Дэглэ авсан гүн, см	Хөрсний хунц металлын агууламж, мг/кг					
		Сг	Рь	Сд	Зн	Су	Нн
Дэглэ 1	0-20	58.1	72.5	0.0	70.4	36.4	16.7

Зөвшөөрөгдөх дэглэ хэмжээ MNS 5850:2019

Элемент	Сг	Рь	Сд	Зн	Су	Нн
Шаврангар хэрс	100	70	1.5	150	80	100
Шаврангар хэрс	150	100	3	300	100	150

*Харгалзах түвшин Жич: Энэхүү шинжилгээний харуу нь тусгай тусгай дээжид хамаарна.

МОНГОНЫ ШИНЖЛЭГЭЭНИЙ АРГААНЫ СТАНДАРТУУД: Шинжилгээний үзүүлэлтүүд
MNS 5297:2019, MNS 11466:2007, Металлын спектрээр шинжилгээний харуу, Эрүүл Ахуйн
Шинжилгээний Стандарт MNS 5297:2019, Хууд металлуудыг хамт дорнод атом шинжилгээний
спектрометрээр MNS ISO 11466:2007

ЗАЛДАН ШИНЖЛЭГЭЭНИЙ ГҮЙЭГТЭХСЭН: ХУУГАШЭЭГ, ДЭГЭРЧЭСЭН
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Р.Д

GN BEVERAGES QUALITY DEPARTMENT ХАБУТ- ЧЖ-01:2017-Б104

REPORT OF LABORATORY ANALYSIS №: 60

Sample name: Air sample Taken : 2023.10.26
Sampled point: GN Beverages LLC factory Analysis date: 2023.10.26
Sample size: 100L Printed on: 2023.10.31
Sampled QC: Purevsuren Kh.

Parameters, units	Manual №:	Standard PepsiCo	Parameters, units	
			1. Yeast/plate	2. Mold/plate
1. Syrup / batching room	TM701.001	50/plate	0	0
2. BIB filling room		0	0	
3. Filler infeed		35/plate	0	2
4. Filler enclosure		1	7	
5. Capper		2	7	

Test made by: Microbiologist: /Purevsuren Kh./
Checked by: Supervisor: /Ankhbayar N./

Энэхүү сорилын тайлан зөвхөн тухайн сорьцонд хамаарна.
(This report is valid only for this sample!)

GN BEVERAGES QUALITY DEPARTMENT ХАБУТ- ЧЖ-01:2017-Б104

REPORT OF LABORATORY ANALYSIS №: 14

Sample name: Air sample Taken : 2023.03.07
Sampled point: GN Beverages LLC factory Analysis date: 2023.03.12
Sample size: 100L Printed on: 2023.03.12
Sampled QC: Purevsuren Kh.

Parameters, units	Manual №:	Standard PepsiCo	Parameters, units	
			1. Yeast/plate	2. Mold/plate
1. Syrup / batching room	TM701.001	50/plate	15	5
2. BIB filling room		1	2	
3. Filler infeed		35/plate	0	5
4. Filler enclosure		2	0	
5. Capper		14	8	

Test made by: Microbiologist: /Purevsuren Kh./
Checked by: Supervisor: /Ankhbayar N./

Энэхүү сорилын тайлан зөвхөн тухайн сорьцонд хамаарна.
(This report is valid only for this sample!)

Зураг 14. Хөрсний болон агаарын шинжилгээ хийлгэсэн байдал

**НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 7. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			сар	сар	сар		
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны аудитыг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэж ирсэн бөгөөд 2021-2022 оны төлөвлөгөөт аудитын “Өртөөлөн ХХК-аар хийлгэсэн.	-		2023 онд			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
2.	“Пепси” ундааны үйлдвэрийн БОННУ-ий тайлангийн хугацаа 2022 онд дууссан бөгөөд БОАЖЯ-ны 12/3486 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлт 2023 онд гарсан. Мөн ХУД-ийн иргэдийн нийтийн хуралдаан 2023 онд хэлэлцэгдэж дэмжигдсэн боловч тус хурлын бичиг баримтын бүрдэл хангагдаагүй улмаас БОННУ-ий нэмэлт тодотголын тайлан 2024 онд БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж баталгаажсан нь тухайн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлэх нөхцөл бүрдсэн.	-		2023 онд			Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам Хөдөлмөрийн тухай хууль, аюулгүй ажиллагааны дүрэм, журам
3.	Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээг “Элемент”, “Грийн химистри” ХХК-тай байгуулсан бөгөөд 2023 онд сунгуулан ажилласан.	900.0		2023 онд			
4.	Уурын дулааны эрчим хүчээр хангах гэрээ, хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ, цэвэр усаар хангах гэрээг тус тус сунгуулан гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	-		2023 онд			
5.	Үйлдвэрлэл, байгаль орчин, үйл ажиллагаатай холбоотой бусад гэрээ хэлцлүүдийг тухай бүрт нь шинэчлэн байгуулж ажилласан.	-		2023 онд			
Нийт		900.0					

“Жи эн бевережис” ХХК-ийн “Пепси” ундааны үйлдвэрийн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ундааны үйлдвэрийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд байгаль орчны аудитыг “Өртөөлөн” ХХК-аар хийлгэсэн бөгөөд 2024 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн.

Химийн бодисын үлдэгдэл агуулсан хоосон сав/хуванцар, шил/, урвалж, хүчлийн хаягдал болон бусад химийн бодисын хаягдал зэргийг “Элемент”, “Грийн химистри” ХХК-д нийлүүлдэг бөгөөд тайлант хугацаанд Аюултай химийн бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээг “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу аюултай хог хаягдлыг шилжүүлж акт үйлдсэн байна.

Зураг 15. Аюултай хог хаягдал болон дахин боловсруулах хог хаягдал нийлүүлэх гэрээний сунгалт хийлгэсэн байдал

Мөн аюултай химийн бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээг “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2022 онд 5.5 кг аюултай хог хаягдлыг нийлүүлж устгуулан акт үйлдүүлсэн. Харин тайлант хугацаанд нэмж аюултай хог хаягдал устгалд оруулаагүй болно.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ
 Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламж
 Хаяг: НД, 3-р хороо Бүс нүүр 12610 гудамж 77 тоот Утас: 7707-3790, 7717-3131
 ELEMENT LLC

2022 оны 11 сарын 07 өдөр Актын дугаар: 22/030 Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: “Жи Эн Бевережис” ХХК

Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт

№	Хаягдлын нэр, төрөл	Тоо ширхэг	Хэмжээ, нэгж /кг, л/	Аюулын ангилал
1	Органик бус бодисын хаягдал	5,5	кг	Идэмхий
2	Хүчлийн хаягдал	11,7	л	Идэмхий
3	Органик бодисын хаягдал	5,25	кг	Идэмхий
4	Цианидын хаягдал	20	л	хортой
5	Урвалж	1,39	кг	-
6	Метанол	0,5	л	шатамхай
7	Үл мэдэгдэх бодис	1,5	л	-
Нийт		45,84	Кг, л	-
1	Химийн бодисын үлдэгдэл агуулсан бодисын хоосон сав /хуванцар, шил /	5,5	кг	-
Нийт		5,5	кг	-

Хүлээлгэн өгсөн: _____ Хүлээн авсан: *В. Аюул*
 УСТГАЛД ОРУУЛАВ



Зураг 16. Устгалд оруулсан аюултай хог хаягдлын акт

Хог хаягдал тээвэрлэх гэрээ, цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ, дулаан, эрчим хүчээр хангах гэрээний сунгалтыг тус тус хийлгэсэн.

ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. БОМТ-ий хэрэгжилтийг олон нийтэд тайлагнасан байдал

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал, хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүх хугацааны турш	50.0	Оролцогч талуудыг холбогдох мэдээллээр хангасан.	ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын танхимд
2.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, БОАЖЯ	ТЖБОМТ-г батлуулж, биелэлтийн тайлангаа дүгнүүлэх	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жил бүрийн 11, 12-р саруудад	-	БОМТ түүний хэрэгжилтийг холбогдох газруудад хүргүүлсэн.	-
3.	ХУД-ийн ЗДТГ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	-		-
4.	3-р хорооны ИНХ	Жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах		Жилийн эцсээр 1 удаа	50.0		ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын танхимд
5.	Нийслэлийн Байгаль орчны газар	Жилийн тайланг хүргүүлж дүгнүүлэх		11 сарын 01-ний дотор	-		НБОГ
Нийт					100.0		

“Пепси” ундааны үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хугацаа дууссан тул “Хос нахиа”ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлсэн. Тус тайланг хэлэлцүүлэх шатанд явагдаж байгаа тул 2023 оны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тайлагнаагүй болно.

Тайлант хугацаанд ХУД-ийн Засаг даргын тамгын газар болон ИНХ-д Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг танилцуулж, хэлэлцүүлсэн.



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ГУРАВДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРАЛДААН**

Огноо 2023.07.05 № 21
танай _____ -ны № _____ -г


**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД**

Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Жи Эн Бевережис” ХХК-ийн “Пепси ундааны үйлдвэр”- ийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлантай танилцлаа.

Тус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж байна.

Хавсралт: 3 хуудас

ДАРГА  Д.МӨНХБАЯР




**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
3 ДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 № 21 УЛААНБААТАР ХОТ

**БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ДЭМЖИХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32-р зүйлийн 32.8.8, 8.10 дахь хэсэг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн хорооны Иргэдийн нийтийн хуралдаанаас тогтоох нь:

1. Тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “ЖИ ЭН БЕВЕРЕЖИС” ХХК-ийн “Пепси ундааны үйлдвэр”- ийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг дэмжсүгэй.
2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд боловсруулагдсан байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан арга хэмжээ болон үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг “ЖИ ЭН БЕВЕРЕЖИС” ХХК-н Гүйцэтгэх захирал /Б.АРИУНАА-д үүрэг болгосугай.
3. Хяналт тавьж ажиллахыг Иргэдийн нийтийн хуралдааны тэмдэглэл, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн хүргэхийг “ЖИ ЭН БЕВЕРЕЖИС” ХХК-н хуулийн зөвлөх /Б.Дөлгөөн/-д үүрэг болгосугай.

ДАРГАЛАГЧ  Д.МӨНХБАЯР

Зураг 18. ХУД-ийн 3-р хорооны ИНХ-ын тогтоол гарсан байдал

ДҮГНЭЛТ

Хүснэгт 9. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв

№	Зардлын ангилал	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	52100.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	15500.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	1500.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	4420.0
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	50.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	900.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	100.0
Нийт төсөв, мян.төг		74570.0

“Жи Эн Бевережис” ХХК нь пепси ундааны үйлдвэрийн 2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт **74570.0** мянган төгрөг зарцуулсан байна.